



144

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 3/134

Ховд

Б.Бат-Оюуныг ажилд томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 417 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Засгийн газрын Тохируулагч агентлаг - Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгасантай холбогдуулан Батбаярын Бат-Оюуныг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Харилцаа, холбооны хяналтын улсын байцаагчаар 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн шилжүүлэн томилсугай.

2. Б.Бат-Оюуныг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Түмэндэмбэрэл)-д үүрэг болгосугай.


3. Б.Бат-Оюуны албан хэрэгцээнд хэрэглэж байсан хөрөнгө болон холбогдох бусад бичиг баримтыг хүлээн авч бүртгэлд тусган ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав (Х.Болормаа), няглан бодогч (Б.Энхмандал) нарт даалгасугай.

4. Б.Бат-Оюуныг Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”-ний ТЗ-6-5 дахь шатлал буюу 853375 (найман зуун тавин гурван мянга гурван зуун далан тав) төгрөгөөр, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн захиргааны болон үйчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу төрийн алба хаасан хугацааны

нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар тооцож, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” 21 дүгээр тогтоолын дагуу зэрэг дэвийн нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингийн 22 хувиар тус тус тооцож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.БАЯРСҮХ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны  
өдрийн Б/134 дүгээр тушаалын хавсралт



## ХӨРӨНГӨ ХҮЛЭЭЖ АВАХ АЖЛЫН ХЭСЭГ

### Ажлын хэсгийн

ахлагч: Б.Нямдэлгэр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,  
аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий  
нягтлан бодогч)

Гишүүд: Б.Энхмандал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
нягтлан бодогч)

Н.Баянжаргал (Мэргэжлийн хяналтын газрын нягтлан  
бодогч)

А.Нямцэцэг (Мэргэжлийн хяналтын газрын нярав)

### Нарийн бичгийн

дарга: Х.Болормаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав)

-оОо-